

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн¹ Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд шүүхийн эрхэм зорилгыг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах гэж тус тус заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн² Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд шүүхийн эрхэм зорилгыг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах гэж тус тус заажээ.

Монгол Улсын хууль тогтомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн³ 47-д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн⁴ 3.2.2.7-д “... иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл, ... эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж заасны дагуу иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сайжруулах хууль, эрх зүй, зохион байгуулалтын цогц арга хэмжээг авах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, олон улсын сайн жишигт хүргэх” гэж тус тус заасан.

Иймд иргэний шийдвэр гүйцэтгэх албаны тогтолцоо, иргэний шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг олон улсын жишигт нийцүүлэх үүднээс уг хуулийн төслийг боловсруулах үндэслэл бүрдсэн.

Хуулийн төслийг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнд үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/104 дүгээр тушаалаар байгуулсан Ажлын хэсгээс боловсруулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг дараах зарчмын шинжтэй өөрчлөлтийн хүрээнд боловсруулна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага Засгийн газрын агентлаг хэвээрээ байхаар, ингэхдээ эрүү, зөрчлийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь төрийн цэргийн алба хаагчдаас бүрдэхээр, харин иргэний болон захиргааны хэргийн шийдвэр

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

³ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралт.

⁴ Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт.

гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага нь тус байгууллагын харьяа алба байхаар, гэсэн хэдий ч төрийн цэргийн алба хаагчийн статусгүй зөвхөн төрийн албан хаагчийн цалин хөлс авах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны урамшуулал авахаар тусгалаа. Ингэснээр төсөвт үүсэх зардал хэмнэх юм.

Иймд хуулийн төслөөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, тэр дундаа иргэний шийдвэр гүйцэтгэх албыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлог, олон улсын жишигт нийцүүлж, цэргийн албаны хууль тогтоомж хамаарахгүй, урамшуулалд суурилсан шуурхай, үр дүнтэй тогтолцоог ялгамжтай байдлаар бий болгосон зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн төсөлд санал авахаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 1/2075 тоот албан бичиг хүргүүлж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагаас санал авч, холбогдох саналыг тусгав.

Мөн хуулийн төслийн хэлэлцүүлгийг 4 удаа зохион байгуулж, хэлэлцүүлэгт оролцогчдын санал, хүсэлтийг хуулийн төсөлд харгалзан үзэж, тусгав.

---oOo---